



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит
хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захирал Н.Одхүүтэй байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.“Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Одхүүтэй байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

300502